



“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ТӨРИЙН ӨМЧИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн “Итгэмжлэлийн журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Боловсруулаагүй бараа, түүхий эдийн агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Боловсруулах үйлдвэрийн агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг гуравдугаар хавсралтаар, “Хүнсний буудайн агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг дөрөвдүгээр хавсралтаар, “Тосны ургамлын агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг тавдугаар хавсралтаар, “Арьс ширний агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг зургадугаар хавсралтаар, “Мах, махан бүтээгдэхүүн хадгалах агуулахад тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг долдугаар хавсралтаар, “Тээвэрлэгчид тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг наймдугаар хавсралтаар, “Сорилтын лабораторид тавигдах итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт”-ийг есдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Итгэмжлэлийн журам болон итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг биржийн ажилтан, харилцагчдад танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нэгжийн менежер нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны А/17 дугаар тушаал болон 2017 оны А/12 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Р.Ариунбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ДАНДИЙ-ЯДАМ

0000000005



Гүйцэтгэх захирлын
2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
A/02 тоот тушаалын 01 дүгээр хавсралт

ИТГЭМЖЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам (цаашид "журам" гэх)-ын зорилго нь "Хөдөө аж ахуйн бирж" ХХК (цаашид "Бирж" гэх)-иар арилжих бараа, түүхий эдийг боловсруулах, хадгалах ажил, үйлчилгээ эрхэлж буй агуулахад "Агуулахын итгэмжлэл олгох", ачаа, тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагад "Тээвэрлэгчийн итгэмжлэл олгох", бараа, түүхий эдийн чанарыг баталгаажуулах сорилтын лабораторид "Лабораторийн итгэмжлэл олгох" /хамтад нь "Итгэмжлэгдсэн этгээд" гэх/ болон бараа, түүхий эдийн агуулах, хүргэлт, чанарын баталгаажуулалтад тавигдах шаардлага, итгэмжлэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Журам нь Монгол Улсын холбогдох хуулиуд, "Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд мөрдөгдөнө.
- 1.3. Биржийн Гүйцэтгэх захирал болон ложистик, барааны нэгж тус журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана.
- 1.4. Энэхүү журмын хавсралтууд нь журмын салшгүй хэсэг байна.

Хоёр. Итгэмжлэл, түүний шалгуур үзүүлэлт

- 2.1. Итгэмжлэл олгох гэдэгт Биржээс тогтоосон итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангасан итгэмжлэл хүсэгчтэй агуулах, тээвэрлэгч болон лабораторийн итгэмжлэл олгох гэрээ байгуулахыг ойлгоно.
- 2.2. Агуулах, тээвэрлэгч болон лабораторийн итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт нь итгэмжлэл хүсэгчид тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн бүрдлийн жагсаалт, итгэмжлэл сунгахад шаардлагатай баримт бичгийг агуулсан байна.
- 2.3. Агуулахын итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах, хадгалах, тээвэрлэх онцлогоос нь хамаарч, бараа, түүхий эдийн нэр төрөл тус бүрт боловсруулж болно.
- 2.4. Итгэмжлэл олгох гэрээний хугацаа, гэрээний сунгалтыг холбогдох нэгжийн саналыг үндэслэн Биржийн Гүйцэтгэх захирал шийдвэрлэх ба гэрээ байгуулахдаа итгэмжлэгдсэн агуулах, тээвэрлэгч болон лабораторийн үйл ажиллагаа, харилцан хамтран ажилласан байдал зэргийг харгалзан үзнэ.

Гурав. Итгэмжлэл олгох

- 3.1. Итгэмжлэл хүсэгч нь итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу баримт бичгийн бүрдлийг бүрдүүлэн Биржид хүлээлгэн өгнө.
- 3.2. Баримт бичгийн бүрдлийг итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн "Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт"-тай тулгаж бүрэн хүлээж авч баталгаажуулсан өдрийг *Баримт бичиг хүлээн авсан өдөрт* тооцно.
- 3.3. Баримт бичиг хүлээн авсан өдрөөс хойш агуулахын итгэмжлэл хүсэгчид ажлын 10 өдөрт багтаан, тээвэрлэгч болон лабораторийн итгэмжлэл хүсэгчид

- ажлын 20 өдөрт багтаан холбогдох нэжийн саналыг үндэслэн Биржийн Гүйцэтгэх захирал дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:
- 3.3.1. Баримт бичгийг буцаах тухай;
 - 3.3.2. Итгэмжлэл олгох гэрээ байгуулах тухай;
 - 3.3.3. Гэрээ байгуулахаас татгалзах тухай.
- 3.4. Баримт бичгийг буцаах тухай шийдвэрийг дараах тохиолдолд гаргана. Үүнд:
- 3.4.1. Баримт бичгийн бүрдлийг гүйцэт хангуулах;
 - 3.4.2. Баримт бичгийн бүрдэлд бодит байдлаас зөрсөн, хуурамч, хүчин төгөлдөр бус баримт, мэдээлэл орсон;
 - 3.4.3. Итгэмжлэл хүсэгч баримт бичгээ буцаан татах хүсэлт гаргасан.
- 3.5. Биржийн итгэмжлэл хүсэгч нь журмын 3.3.1-д заасан шийдвэр гарснаас хойш Биржид ажлын 5 өдрийн дотор санал, хүсэлт гаргаж болно.
- 3.6. Журмын 3.3.2, 3.3.3-т заасан шийдвэрийг Биржийн Гүйцэтгэх захирал гаргана. Хэрэв 3.3.3-т заасан шийдвэр гаргасан бол татгалзах үндэслэлийг шийдвэрт тусгаж хүргүүлнэ. Энэхүү шийдвэр нь Биржийн Гүйцэтгэх захирлын эцсийн шийдвэр байна.
- 3.7. Итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байх нь Биржээс итгэмжлэл хүсэгчтэй гэрээ байгуулах зайлшгүй нөхцөл болохгүй.
- 3.8. Агуулахын итгэмжлэл хүсэгч нь нэгээс доошгүй бараа, түүхий эдийн нэр төрлөөр агуулахын итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдийг зэрэг хангаж, агуулахын итгэмжлэл хүсч болно.
- 3.9. Итгэмжлэгдсэн агуулах бусад бараа, түүхий эдийн нэр төрлөөр итгэмжлэл хүсч болох бөгөөд энэ тохиолдолд Биржээс холбогдох бараа, түүхий эдийн итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд заасан баримт бичгийг нэмж бүрдүүлэхийг шаардана.
- 3.10. Журмын 3.3.2-т заасан шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор итгэмжлэл олгох гэрээг байгуулах ба Биржийн цахим системд бүртгэж, Агуулахын програмын ашиглалтын талаар агуулахын итгэмжлэгдсэн этгээдэд зааварчилгаа өгнө.
- 3.11. Дараах тохиолдолд Биржийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр агуулахын итгэмжлэл олгох гэрээнд тусгасан бараа, түүхий эдийн нэр төрөлд өөрчлөлт оруулна. Үүнд:
- 3.11.1. Бараа, түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлэх (хасуулах) хүсэлт гаргасан, эсвэл энэ үндэслэл Биржийн шалгалтаар тогтоогдсон;
 - 3.11.2. Барааны тодорхойлолт, гэрээний стандартад өөрчлөлт орсон, Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт өөрчлөгдсөн.

Дөрөв. Итгэмжлэгдсэн агуулахын үйл ажиллагаа

- 4.1. Агуулахын итгэмжлэл олгох гэрээг итгэмжлэл хүсэгчтэй байгуулж "Итгэмжлэлийн гэрчилгээ" олгосон өдрийг *Итгэмжлэл олгосон өдөрт* тооцно.
- 4.2. Биржээр арилжих бараа, түүхий эдийг хүлээн авахаас эхлэн автотээврийн хэрэгсэл дээр ачиж дуусах хүртэлх үйл ажиллагааг итгэмжлэгдсэн агуулах хариуцна.
- 4.3. Итгэмжлэгдсэн агуулах нь итгэмжлэл авсан бараа, түүхий эдийн нэр төрөл тус бүрээр Монгол Улсын холбогдох стандартад заасан хадгалалтын нөхцлийг тогтмол баримталж ажиллана.
- 4.4. Итгэмжлэгдсэн агуулах нь дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- 4.4.1. Биржээр арилжих бараа, түүхий эдийг хүлээн авах /Хавсралт 1/;
- 4.4.2. Харилцагчийн хүсэлтээр боловсруулалт хийх;
- 4.4.3. Бараа, түүхий эдийг хадгалах;
- 4.4.4. Монгол Улсын холбогдох стандартын дагуу бараа, түүхий эдэд анхан шатны тордолт, чанарын хамгаалалт заавал хийх /MNS5094:2013, MNS0215:2018/; /Хавсралт 2/
- 4.4.5. Бараа, түүхий эдийг хүлээлгэн өгөх, ачих /Хавсралт 3/;
- 4.4.6. Агуулахын програмд харилцагчийн бараа, түүхий эдийн хөдөлгөөнийг үнэн зөв хөтлөх;
- 4.4.7. Бараа, түүхий эдийг хүлээн авсан, тордолт, чанарын хамгаалалт хийсэн, боловсруулалт хийсэн, хүлээлгэн өгсөн талаархи баримтыг тухай бүр үйлдэх;
- 4.5. Дор дурдсан үйл ажиллагааг харилцагчийн хүсэлтийн дагуу бараа, түүхий эдэд боловсруулалт, үйлчилгээ хийхэд хамруулж ойлгоно. Үүнд:
 - 4.5.1. *Үнэлэх:* Бараа, түүхий эдийн физик, механик шинж чанарыг мэдрэхүйн эрхтний туслалцаатайгаар үнэлж, тодорхойлох;
 - 4.5.2. *Тордох:* Бараа, түүхий эдийг нэр төрлөөр нь зориулалтын дагуу тордох, задлан сэгсэрч элдэв хогноос нь салган цэвэрлэх, давслаж хатаах, өнгө, зэрэг, төрөл чанараар нь ялган ангилах;
 - 4.5.3. *Үйлдвэрийн аргаар боловсруулах:* Бараа, түүхий эдийг үйлдвэрийн аргаар боловсруулах;
 - 4.5.4. *Жинлэх:* Бараа, түүхий эдийг анхан шатны цэвэрлэгээ, тордолтын дараа цэвэр жинг, баглалт (савлалт) бүслүүрдсэний дараа бохир жинг тус тус тодорхойлох;
 - 4.5.5. *Баглах:* Бараа, түүхий эдийг тухайн онцлогт нь тохируулан стандартын дагуу баглах (савлах), тээвэрлэхэд бэлтгэх;
 - 4.5.6. *Хаяглах:* Бараа, түүхий эдийн нэр, код, харилцагчийн нэр, цэвэр, бохир жин, огноо, бараа, түүхий эдийн мэргэжилтэний мэдээлэл, итгэмжлэгдсэн агуулахын дугаарыг тус тус гаргацтай тэмдэглэх.
- 4.6. Бараа, түүхий эдэд боловсруулалт, үйлчилгээ хийсэн хөлсийг агуулахын тариф, эсвэл харилцагчтай байгуулсан гэрээгээр зохицуулна.
- 4.7. Биржээр арилжих бараа, түүхий эдийг Агуулахын програмд арилжаа эхлэхээс өмнөх ажлын өдрийн 12:00 цагаас өмнө бүртгэсэн байна. Тогтсон хугацаанаас хойш агуулахын програмд бүртгэгдсэн бараа, түүхий эдийг дараагийн арилжааны өдрийн арилжаагаар оруулна.
- 4.8. Итгэмжлэгдсэн агуулах нь хадгалуулах бараа, түүхий эдийн гарал үүслийн бичгийг харилцагчаас шаардах, шаардлагатай тохиолдолд тухайн бараа, түүхий эдийг лабораторийн шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 4.9. Итгэмжлэгдсэн агуулах нь Агуулахын програмын бүртгэл болон баримтын хөтлөлтийг Биржийн ложистик, барааны нэгжид шалгуулах үүргийг хүлээнэ.

Тав. Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйл ажиллагаа

- 5.1. Тээвэрлэгчийн итгэмжлэл олгох гэрээг итгэмжлэл хүсэгчтэй байгуулж "Итгэмжлэлийн гэрчилгээ" олгосон өдрийг *Итгэмжлэл олгосон өдөрт* тооцно.
- 5.2. Улс хооронд болон дотоодод дамжуулан тээвэрлэх Биржээр арилжсан хүргэлтийн бараа, түүхий эдийг итгэмжлэгдсэн тээвэрлэгч тээвэрлэнэ.



- 5.3. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь бараа, түүхий эдийг ачиж, тээвэрлэлт хийж эхэлснээс хойш хүлээн авах агуулахад буулгаж, бараа хүлээлцсэн баримт үйлдэх хүртэл хугацаанд тээвэрлэж буй бараа, түүхий эдийн чанар, хэмжээ, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 5.4. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь Монгол Улсын автотээврийн хэрэгслийн тоо бүртгэл, техникийн улсын үзлэгт хамрагдсан, албан татвар, даатгалыг бүрэн төлсөн, осол зөрчилгүй зорчих нөхцөл бүрдүүлсэн, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" /MNS 4598-2003/ стандартын шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэлт хийнэ.
- 5.5. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь хүргэлт хийх автотээврийн хэрэгслийн жолоочийн хаалганы төв хэсэг, урд шилний баруун дээд буланд "Итгэмжлэгдсэн автотээврийн хэрэгсэлийн таних тэмдэг"-ийг байрлуулна. /Хавсралт 4/
- 5.6. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь Биржээр арилжсан хүргэлтийн бараа, түүхий эдийг худалдан авсан харилцагчтай ачилт, буулгалт, маршрут, тээвэрлэлтийн нөхцлийг тохирч, Иргэний хууль болон Автотээврийн тухай хуульд нийцсэн тээвэрлэлтийн гэрээг байгуулсан байна.
- 5.7. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь ачаа тээвэрлэх зориулалтын бүх төрлийн автотээврийн хэрэгсэл, тэдгээрт засвар үйлчилгээ хийх, автотээврийн хэрэгслийг агуулах зориулалтын барилга байгууламж, гараж, тоног төхөөрөмжтэй, мэргэжлийн инженер, техникийн ажилтан, мэргэшсэн жолооч, засварын ажилтануудтай байна.
- 5.8. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварыг тогтоосон хуваарь, горимын дагуу гүйцэтгэсэн, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлага хангасан, техникийн хяналтын үзлэг, оношлогоонд заасан хугацаанд хамрагдаж тэнцсэн автотээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.
- 5.9. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг зөвхөн тухайн ангилалын мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх бөгөөд автотээврийн хэрэгслийг зориулалтын гараж, зогсоол, талбайд байрлуулна.
- 5.10. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь бараа, түүхий эдийг тээврийн хэрэгслийн эд ангид нуух, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд хориотой бараа тээвэрлэх зорилгоор тоноглохыг хориглоно.
- 5.11. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь бараа, түүхий эдийн хүргэлтийг гүйцэтгэх бүрт ачаа тээвэрлэлтийн дэлгэрэнгүй мэдэгдэлийг хөтөлж Биржийн ложистик, барааны нэгжид ирүүлнэ. /Хавсралт 5/

Зургаа. Итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаа

- 6.1. Лабораторийн итгэмжлэл олгох гэрээг итгэмжлэл хүсэгчтэй байгуулж "Итгэмжлэлийн гэрчилгээ" олгосон өдрийг *Итгэмжлэл олгосон өдөрт* тооцно.
- 6.2. Итгэмжлэгдсэн лаборатори нь Биржээр арилжих бараа, түүхий эдээс сорьц, дээж авахаас эхлэн сорилт шинжилгээг гүйцэтгэх, сорилт, шинжилгээний үр дүнг боловсруулах, сорилтын дүнг баталгаажуулах, үнэн зөв сорилтын дүнгээр харилцагчийг хангах үйлчилгээг үзүүлнэ.
- 6.3. Итгэмжлэгдсэн лаборатори нь бараа, түүхий эдийн нэр төрөлд тохирох Монгол Улс болон олон улсын холбогдох стандарт арга, аргачлалаар зөвхөн

- итгэмжлэлийн хүрээндээ хамрагдах сорилт, шинжилгээг хийж баталгаажуулна.
- 6.4 Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгийн хуудсанд шинжилсэн шинжээч гарын үсэг зурах ба лабораторийн захирал, эрхлэгч гарын үсэг зурж, тамгалж баталгаажуулна.
- 6.5 Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгийн хуудас нь лабораторийн лого, дээжийн мэдээлэл, сорилт шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, тухайн бараа, түүхий эдийн зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, гарсан үр дүн зэрэг мэдээллүүдийг багтаасан байна. /Хавсралт 6/
- 6.6 Итгэмжлэгдсэн лаборатори нь шинжилгээнд хүрэлцэхүйц хэмжээний дээж хүлээн авч 2 хуваан 1 хэсэгт сорилт шинжилгээг хийж, үлдсэн хувийг шинжилгээний дүнг хүлээлгэн өгсөнөөс хойш 60-аас доошгүй хоног хадгална.
- 6.7 Итгэмжлэгдсэн лаборатори нь шаардлагатай тохиолдолд дээж, сорьцыг дараагийн шатлалын лабораториор гүйцэтгүүлж, сорилтын дүнгээ баталгаажуулж болох бөгөөд үүнтэй холбоотой үүсэх зардлыг бүрэн хариуцна.
- 6.8 Итгэмжлэгдсэн лаборатори нь сорилтын дүнгийн үнэн зөвийг бүрэн хариуцан хараат бус ажиллана.
- 6.9 Итгэмжлэгдсэн лаборатори нь шинжилгээнд дээж авсан, шинжилгээ хийсэн, шинжилгээний хариу өгсөн, дээж хадгалсан болон устгасан тухай бүртгэлийг хөтлөх бөгөөд шинжилгээнд хамруулсан бараа, түүхий эдийн мэдээллийг улирал тутам Биржийн ложистик, барааны нэгжид ирүүлнэ.

Долоо. Даатгал

- 7.1 Итгэмжлэгдсэн агуулах нь өөрийн эзэмшлийн агуулах, бараа, түүхий эд хадгалах зориулалтын байр болон тус байранд буй бараа, түүхий эд, туслах материал, тоног төхөөрөмжид гэнэтийн, урьдчилан таашгүй явдал тохиолдсоноос учирч болзошгүй хохирлыг арилгах зорилгоор Иргэний хууль, Даатгалын хууль болон бусад холбогдох хуулинд нийцүүлсэн гэрээг даатгалын байгууллагатай урьдчилан байгуулж ажиллана.
- 7.2 Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь зорчигч болон гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, ачаа тээшинд учирч болзошгүй хохирлыг арилгах зорилгоор Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Автотээврийн тухай хууль болон бусад холбогдох хуулинд нийцүүлсэн гэрээг даатгалын байгууллагатай урьдчилан байгуулж ажиллана.
- 7.3 Бараа, түүхий эдийг хадгалах, тээвэрлэх явцад үүсэх аливаа эрсдэлийг Итгэмжлэгдсэн этгээд бүрэн хариуцна.

Найм. Итгэмжлэлийн хураамж

- 8.1 Итгэмжлэл хүсэгч этгээд нь итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангуулахаар бүрдүүлсэн баримт бичгийн бүрдлийг Бирж хянаж тус шалгуур үзүүлэлтийг хангасан нь тогтоогдсоноор итгэмжлэл олгох шийдвэр гарсаны дараа итгэмжлэл хүсэгчтэй итгэмжлэл олгох гэрээ байгуулж итгэмжлэлийн гэрчилгээний хураамжийг Биржид төлнө.
- 8.2 Итгэмжлэлийн гэрчилгээний хураамжийн төлбөрийн хэмжээг Биржийн Гүйцэтгэх захирал батална.

Ес. Мэдээлэл солилцох

- 9.1 Итгэмжлэл олгох гэрээнд бүртгэгдсэн хаяг, утас, цахим шуудан болон биржийн цахим системд холбогдсон програм хангамжийг Биржийн мэдээлэл солилцох суваг гэж ойлгоно. Хэрэв мэдээлэл солилцох сувагт өөрчлөлт орсон бол итгэмжлэгдсэн этгээд нь энэ тухай мэдээллийг ажлын 3 өдрийн дотор албан бичгээр баталгаажуулан Биржид мэдэгдэнэ.
- 9.2 Итгэмжлэгдсэн агуулах, тээвэрлэгч болон лабораториос Биржид гаргах хүсэлтийг албан бичгээр, Биржээс итгэмжлэгдсэн агуулах, тээвэрлэгч болон лабораторитой харилцах баримт бичгийг өөрийн цахим шуудангаар, эсвэл албан бичгээр илгээснийг хүчин төгөлдөрт тооцно.
- 9.3 Биржийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн мэдээ, мэдээллийг Биржийн цахим хуудаст байршуулна. Цахим хуудас дахь мэдээ, мэдээлэл, дүрэм, журам болон холбогдох баримт бичгийг Биржийн албан ёсны эх сурвалж гэж үзнэ.

Арав. Хяналт, шалгалт, зөрчил, хариуцлага

- 10.1 Биржээр арилжих бараа, түүхий эдийн чанар, хэмжээтэй холбоотой үүссэн аливаа маргааныг Хяналтын журамд заасны дагуу зохицуулна.
- 10.2 Итгэмжлэгдсэн этгээдийн үйл ажиллагаанд илэрсэн аливаа зөрчил, түүнд ногдуулах хариуцлагыг Хяналтын журамд заасны дагуу зохицуулна.

Арваннэг. Итгэмжлэлийн сунгалт, дуусгавар болгох

- 11.1 Итгэмжлэгдсэн этгээд итгэмжлэл олгох гэрээг сунгуулах хүсэлт гаргахдаа гэрээний хугацаа дуусахаас ажлын 10 өдрөөс доошгүй хугацааны өмнө Биржид албан бичгээр хүсэлт гаргана.
- 11.2 Итгэмжлэл сунгуулах хүсэлт гаргагч нь холбогдох итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн итгэмжлэл сунгуулахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлж Биржийн ложистик, барааны нэгжид хүлээлгэн өгнө.
- 11.3 Итгэмжлэл сунгуулах хүсэлт гаргасан итгэмжлэгдсэн этгээд нь Итгэмжлэлийн журмын заалт, итгэмжлэл олгох гэрээний нөхцөлийг зөрчсөн тохиолдол илрээгүй бол Биржийн Гүйцэтгэх захирлын шийдвэрийг үндэслэн итгэмжлэлийг сунгана.
- 11.4 Биржийн итгэмжлэл олгох гэрээг сунгах эсэхийг энэ журмын 3.3-т заасны дагуу шийдвэрлэнэ. Энэ шийдвэр нь агуулах, тээвэрлэгч болон лабораторийн итгэмжлэл олгох гэрээний үүргийн биелэлтээс хамаарна.
- 11.5 Итгэмжлэгдсэн этгээд нь итгэмжлэлээ сунгуулах хүсэлт гаргаагүй нь итгэмжлэл олгох гэрээ дуусгавар болох үндэслэл болно.



**БИРЖЭЭР АРИЛЖИХ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙГ ХҮЛЭЭН
АВАХ БАРИМТ**

№

20 ... он ... сар ... өдөр

БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Барааны нэр: _____ Барааны код: _____
Хэмжээ: _____ (кг, ш) Барааг хадгалсан агуулахын дугаар: _____

ХАРИЛЦАГЧ

Нэр: _____	Агуулахын нэр: _____
Регистрийн дугаар: _____	Утас: _____
Харилцагчийн данс: _____	Хүлээлцсэн мэргэжилтний нэр: _____
Утас: _____	Албан тушаал: _____
Гарын үсэг: _____	Гарын үсэг: _____

БАРААНЫ БРОКЕР:

Брокерийн компанийн нэр: _____
Барааны брокерийн нэр: _____ Гарын үсэг: _____



ИТГЭМЖЛЭГДСЭН АГУУЛАХАД АНХАН ШАТНЫ
ТОРДОЛТ, ЧАНАРЫН ХАМГААЛАЛТ ХИЙСЭН ТУХАЙ
ТОДОРХОЙЛОЛТ

№

20 ... он ... сар ... өдөр

ТОДОРХОЙЛОЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Тодорхойлолт гаргасан мэргэжилтний нэр: _____

Тордолт, чанарын хамгаалалт хийсэн
ажилтны нэр: _____


Итгэмжлэл олгох гэрээний дугаар: _____

Барааны код, хэмжээ (кг, ш): _____

Барааны нэр төрөл: _____

Хийсэн тордолт, чанарын хамгаалалтын
стандарт, дугаар: _____

Тодорхойлолтын хүчинтэй хугацаа: _____

Тордолт, чанарын хамгаалалт хийсэн
барааны баталгаажсан зураг: 

Хүлээн авагч харилцагчийн мэдээлэл: _____

Хүлээн авах газрын хаяг: _____



**АГУУЛАХААС БИРЖИЙН БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙГ
ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ АЧУУЛАХ БАРИМТ**

№

20 ... он ... сар ... өдөр

БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Барааны нэр: _____

Барааны код: _____

Хэмжээ: _____ (кг, ш)

Барааг хадгалсан агуулахын дугаар: _____

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН

АГУУЛАХ

Агуулахын нэр: _____

Утас: _____

Хүлээлцсэн мэргэжилтний нэр:

Гарын үсэг: _____

ХҮЛЭЭН АВСАН

Байгууллагын нэр: _____

Хүлээн авагчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Утас: _____

Харилцагчийн данс: _____

Гарын үсэг: _____

БАРААНЫ БРОКЕР:

Брокерийн компанийн нэр: _____

Барааны брокерийн нэр: _____ Гарын үсэг: _____





ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙСЭН МЭДЭГДЭЛ

№

20 ... он ... сар ... өдөр

БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ

Арилжааны хэлцлийн дугаар: _____ Тээвэрлүүлэгчийн нэр: _____

Барааны нэр: _____ Хэмжээ: _____ (кг, ш)

Ачаа хүлээн авсан газрыг хаяг: _____

Ачсан огноо: _____

Ачаа хүлээлгэн өгсөн газрын хаяг: _____

Буулгасан огноо: _____

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Жолоочийн овог, нэр: _____

Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар: _____

Лаборатори
логоИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН НЭР
/хаяг/Итгэмжлэлийн
лого

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Протоколын дугаар	Бүтээгдэхүүний стандарт дугаар	Сорьцын тодорхойлолт

СОРЬЦЫН НЭР: _____

СОРЬЦ АВСАН ХҮНИЙ ОВОГ, НЭР, АЛБАН ТУШААЛ: _____

Сорьцын хэмжээ	Сорьц авсан огноо	Шинжилсэн огноо

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Шинжлэх аргын стандартын дугаар	Шинжилсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ	Үр дүн

ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ШИНЖЭЭЧ: _____

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: _____

/Тамга, тэмдэг/